



Их, дээд сургууль, коллежийн оюутнуудын дунд

“Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй”-сэдэвт

Эссэ бичлэгийн уралдаан зарлах тухай

Эрүүл мэндийн салбар үүсч хөгжсөний 90 жилийн ойд

ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооноос зарлаж буй эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн чиглэлээрх эссэ бичлэгийн уралдаанд оюутан залуус Та бүхнийг өргөнөөр оролцохыг урьж байна.

Уралдаанд их, дээд сургууль, коллежид суралцаж буй оюутнууд оролцох боломжтой бөгөөд ёс зүйн чиглэлээр бүтээлч, шинэ санал, санаачилгаа эссэ хэлбэрээр бичиж уралдаанд оролцоно.

Эссэ бичлэгийн сэдэв: Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, түүнийг хэрхэн сайжруулах, эмчийн нэр хүндэд нөлөөлөх сөрөг хүчин зүйлс, бууруулах арга замын талаар өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлнэ.

Уралдаанд ирүүлэх бүтээлд Arial 12 фонтоор, мөр хоорондын зай 1,5-аар бичих, А4 хэмжээтэй цаасан дээр 750-1000 үгэнд багтаах шаардлага тавигдана. Бичлэгийн төгсгөлд зохиогчийн бүтэн нэр, холбоо барих хаяг, сургуулийн хаяг, э-майл хаяг, утсыг бичсэн байна.

Шилдгээр шалгарсан бичлэгийн зохиогчийн эрхийг ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хороо эдэлнэ гэдгийг хүлээн зөвшөөрсөн захидал хавсаргасан байхыг анхаарна уу.

Уралдаанд оролцох эссэ бичлэгийг 2011 он 03 дугаар сарын 07-ны өдрийн 18.00 цаг хүртэл bayarmaa_d@moh.mn цахим шуудангийн хаягаар болон ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар /311 тоот/-т хүлээн авна. Хугацаа хоцорсон бичлэгийг хүлээн авахгүй болно.

Шалгаруулалтыг ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хорооны гишүүдээс бүрдсэн комисс, Монголын анагаах ухааны боловсролын хүрээлэнгийн төлөөлөгч нар шүүн явуулна.

Шилдэг бүтээлийг 2011 оны 03 дугаар сарын 14-ний өдөр олон нийтэд зарлана.

Шагналын сан: Дурсгалын зүйл, 500,000 төгрөг

Лавлах утас: 51-263734, 88619200

ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газар

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
ЁС ЗҮЙН ХОРОО
МОНГОЛЫН АНАГААХ УХААНЫ БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН